42

МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 19 өдөр Дугаар А/685 Мөрөн сум

Барилга, байгууламж ашиглалтад оруулах
комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.2, 35.1.6, 48 дугаар зүйлийн 48.6, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөвсгөл аймгийн Улаан-Уул суманд баригдсан 320 хүүхдийн суудалтай сургуулийн барилгыг байнгын ашиглалтад оруулах чиг үүрэг бүхий комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:

| | |
|---|---|
| Б.Энхжаргал | (Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Барилга хот байгуулалтын хэлтсийн дарга |

Гишүүд:

| | |
|---|---|
| Э.Аззаяа | (Аймгийн Ерөнхий архитектор) |
| Г.Батхүү | (Боловсрол газрын Төсвийн гүйцэтгэл, хөрөнгө оруулалт хариуцсан ахлах арга зүйчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч) |
| Г.Ням-Эрдэнэ | (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасгийн Сан хөмрөгийн эрхлэгч) |
| Д.Аюушжав | (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Эрчим хүчний хяналтын улсын байцаагч) |
| Б.Гал-Эрдэнэ | (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Мэдээлэл харилцаа холбооны хяналтын улсын байцаагч) |
| Д.Мягмарсүрэн | (Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Барилга техник хяналтын улсын байцаагч) |
| Г.Даваадорж | ("Хөвсгөл эрчим хүч" ХХК-ийн Ерөнхий инженер) |
| С.Анхбаяр | (Аймгийн Онцгой байдлын газрын Гал түймрийн улсын хяналтын ахлах байцаагч) |

6712012083

Б.Цэнддэлгэр (Аймгийн Орон нутгийн өмчийн газрын ахлах мэргэжилтэн)

Ц.Бямбатөр (Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Газрын удирдлагын хэлтсийн мэргэжилтэн)

Зураг төслийн байгууллагын төлөөлөл:
С.Энхбаатар (“ТэТү” ХХК-ийн захирал)

Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл:
М.Ананд (“Есүй-Ордон” ХХК-ийн гүйцэтгэх захирал)

Ашиглагч байгууллагын төлөөлөл:
Д.Батцэнгэл (Улаан-Уул сумын Засаг дарга)
А.Нансалмаа (Улаан-Уул сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал)

Комиссын нарийн бичгийн дарга:
Н.Шинэбаяр (Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын ахлах мэргэжилтэн)

2.Барилга байгууламжийн ажлыг хүлээж авах үйл ажиллагааг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулж, комиссын ажлын тайлан, шийдвэрийг олон нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Комиссын дарга (Б.Энхжаргал)-д даалгасугай.

3.Барилга байгууламжийн ажлыг хүлээж авсантай холбоотой баримт бичгийг бүрдүүлэн аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасаг болон холбогдох байгууллагуудад хүлээлгэн өгөхийг Комиссын нарийн бичгийн дарга (Н.Шинэбаяр)-д үүрэг болгосугай.

4.Комиссын бүрэлдэхүүн чанаргүй барилга байгууламж хүлээн авсан хуурамч баримт бичиг бүрдүүлсэн, хууль тогтоомж зөрчсөн тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгүүлэхийг анхааруулсугай.

5.Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Ц.Гансүх)-д үүрэг болгосугай.

ДАРГА Л.ТӨМӨРБААТАР